

“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 2 сарын 28-ны өдөр

Улаанбаатар хот

Хот Девелопмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023 оны 2 сарын 28-ны өдрийн 10:00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж, Бодь цамхаг, 2-р давхар, Дорчестер клуб, Улаанбаатар өрөөнд эхлэв.

Хурлын дэгийн дагуу 09:30 хүртэл ирц бүртгэсэн.

Тооллогын комиссын дарга Г.Ганхүү: 2023 оны 2-дугаар сарын 28-ны өдрийн дугаар номер 1 Улаанбаатар, хот. Монгол Улсын Компанийн тухай хуулийн хуулийн 63.7, 67.3 69.1 дэх хэсэгт Хот Девелопмент ХК-ийн дүрмийн 3.14 болон Хот Девелопмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссийн дүнг үндэслэн тогтоох нь 1-т “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 8,421,521 ширхэг энгийн хувьцаа эзэмшиж буй 3 /гурав/ хувьцаа эзэмшигчид оролцож, нийт саналын эрх бүхий 8,470,054 ширхэг хувьцааны 99.43% хувь болж байгааг хуралд оролцогчдод болон хурлын даргад мэдээлсүгэй. 2-т Компанийн тухай хуулийн 69.1 болон 69.2 дахь заалт, компанийн дүрмийн 3.14 дэх заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 99.43% эзэмшдэг хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байгаа тул хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: За тооллогын комиссын даргадаа баярлалаа. Одоо Хурлын дарга Чинбатын Солонго нээж үг хэлээд хурлын дэгийг танилцуулна.

Хурлын дарга, хувьцаа эзэмшигч Ч.Солонго: Хот Девелопмент ХК-ийн 2022 оны үр дүн болсон ээлжит хурлыг 4 сарын 30-ны дотор Компанийн хуулийн дагуу зохион байгуулдаг байгаа. Үүнийхээ дагуу 2 сарын 28-ны өдөр буюу өнөөдөр зохион байгуулж байна. Өнөөдрийн хурлаар нийтдээ 11 асуудлын хүрээнд хэлэлцэхээр байгаа. Хурлын дэг дотор хэлэлцэх асуудлын жагсаалт ерөнхийдөө багтчихсан учраас жагсаалтыг тусад нь танилцуулахгүйгээр дэгээ танилцуулъя. Өнөөдрийн хуралд нийт одоогийн байдлаар бол 3 хувьцаа эзэмшигч оролцож байгаа. За хурал бол 10 цагтаа эхлээд 13 цаг хүртэл үргэлжлэхээр товлөгдсөн байгаа. Хурлын ирцийг бүртгээд тооллогын комиссын дарга дууссан. Ирцийн үр дүнг бол мэдээлчихсэн байгаа. Хэлэлцэх асуудлуудын нэгдүгээр жагсаалтынх нь хүрээнд бол өнгөрсөн 2022 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлах ёстой байгаа. За 2 дахь асуудал нь бол санхүүгийн тайланд хувьцаат компани зохицуулалттай этгээд учраас хөндлөнгийн аудит орж жил бүр санхүүгийн тайлан аудитлагдах ёстой за үүний дагуу 2022 оны тайланд Пантер Мидланд аудитын компаниас аудит хийсэн энэ тухай танилцуулна. Гуравдугаарт нь 2023 оны үйл ажиллагааныхаа төлөвлөгөө болон үүнтэй дагалдан гарах төсвийг батлах шаардлагатай байгаа. Дөрөв дэх асуудлын хүрээнд өнгөрсөн онд бүрэн эрхээ хэрэгжүүлж ирсэн ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, за шинээр гишүүдийг томилох асуудлыг хэлэлцэнэ. Нэр дэвшиж байгаа ТУЗ-ийн гишүүдийн мэдээллийг бас танилцуулах хэсэг дээр оруулж өгсөн байгаа. За дараагийн асуудлын хүрээнд шинээр томилогдсон нийт гишүүдийн 3 нь бол хараат бус гишүүн байгаа. Уг хараат бус гишүүдийн цалин урамшуулал, тухайн ТУЗ-ийн хурлыг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагааны зардлын төсвийг батлах байгаа. Дараагийн асуудал нь ТУЗ-өөс 2022 оны компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн үр дүнтэй уялдаад ногдол ашиг тараахгүй байх тухай шийдвэр гарсан байгаа. Үүнийг танилцуулна. За дараагийн асуудалд нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өсгөх, энэ хүрээндээ хаалттай хувьцааг нэмж гаргах тогтоолын төслийг батлах энэ асуудлыг хэлэлцэнэ. Дараагийнх нь үйл ажиллагааны чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн байгаа үүн дээр бас хэлэлцэж шийдвэрлэх шаардлагатай байна.

11 цаг 40 минут хүртэл хурлынхаа дэгийн дагуу эдгээр нийт 11 асуудлыг хэлэлцээд саналыг үндэслэн шийдвэрлээд явна. Хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргаж байгаатай холбоотойгоор хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх гаргаж байгаа хувьцаагаа санал болгох, тэргүүн ээлжид худалдан авах саналыг тавих уу үгүй юу гэдгийг хурлаар мөн хэлэлцэнэ. Одоогийн байгаа хувьцаа эзэмшигч нар компани руу хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргахтай холбоотой шаардах эрхийг хэрэгжүүлэх эсэх дээр бас шийдвэрийг гаргах ёстой байна. За сүүлийн 11 дэх асуудал бол компанийн дүрэмд мэдээж дээрх үйл ажиллагаа бүтэц зохион байгуулалт, нэмж хувьцаа гаргахтай холбоотой асуудлуудын хүрээнд бол дүрмийн нэмэлт өөрчлөлтийг баталж шинэчлэх шаардлага байгаад байгаа юм. За эдгээр 11 асуудлын хүрээнд 12 цаг 10 минут хүртэл бид нар төлөвлөсний дагуу хуралдах ёстой. Үүний дараа асуулт хариултын 5 минут яваад, санал хураалт 5 минутын турш буюу 12:15-аас 12:20-ийн хооронд, хурлын завсарлагааг 5 минутад байхаар төлөвлөсөн. Хурал завсарлаж байх хооронд тооллогын комисс үр дүнгээ танилцуулах 10 минут байгаа. Тэгээд хурлаас гарах шийдвэр тогтоолыг мөн дараагийн 10 минутад танилцуулаад хурлыг 12:45-аас 1-ийн хооронд хаахаар ийм хурлын дэг, төлөвлөгөөтэй явж байгаа.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: Хурлын даргадаа баярлалаа. Одоо хувьцаа эзэмшигчдээс авах саналын хуудсыг тарааж өгье. За тэгвэл одоо хэлэлцэх асуудалдаа шууд ороод явах уу? Бал байхгүй бол надаас авч болно.

Хэлэлцэх асуудал 1 Хот Девелопмент ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах

За хэлэлцэх асуудлын нэгд болохоор Хот девелопмент компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах гээд энэ асуудал байгаа. Энэ асуудлын хүрээнд бол бид нар 2022 оны үйл ажиллагааныхаа тайланг бол СЗХ-ноос баталсан маягтын дагуу МХБ болон СЗХ-нд тайлант хугацаанд нь буюу 2 сарын 8 болон 2 сарын 14-нд бол тус тус хүргүүлчихсэн байгаа. Энэ тайлантай холбоотойгоор ТУЗ-өөс дүгнэлт гардаг. Энэ яадаг дүгнэлт вэ гэхээр 2022 ондоо энэ Хот девелопмент компани нь ямар үйл ажиллагаа эрхэлсэн юм одоо ХЭХ хуралдсан юм уу хуралдсан бол ямар асуудлыг шийдвэрлэсэн юм санхүүгийн тайлан нь ямар байгаа юм гээд ерөнхийд нь багцлаад дүгнэсэн. 2 сарын 8-ны өдрийн 23/04 гэсэн тооттой төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт гарсан байгаа. 2022 ондоо бол Хот Девелопмент компанийн ХЭХ нэг удаа болсон энэ нь 2022 оны 5 сарын 6-ны өдөр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдсан байгаа. Энэхүү хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаараа ерөнхийдөө 5 асуудлыг авч хэлэлцсэн. Нэгдүгээрт болвол компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах. Одоо энэ чинь 2022 оны 5 сард хуралдсан хурал болохоор 2021 оныхоо үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангаа баталсан байсан. Хоёрдугаарт хараат бус аудитын дүгнэлтийг баталсан. Пантер мидланд аудит гээд хараат бус аудитын компаниар нягтлан бодох бүртгэл аудитын үйл ажиллагааг гүйцэтгээд Хот Девелопмент компанийн 2021 оны санхүүгийн тайлангууд нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу ямар нэгэн материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн байна гэж ийм дүгнэлт гарсан байсан. Энийг ТУЗ-өөс хэлэлцэж баталсан байсан. 3 дахь асуудал нь бол компанийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсан байсан. Эндээ ямар үйл ажиллагаа эрхлэхээр төлөвлөсөн байсан бэ гэхээр шинэ чиглэлд үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн байсан. Эндээ төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ гэж заасан байсан. Гэхдээ бол 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа бол хийгээгүй байгаа. 4-т нь бол ТУЗ-ийн 2022 оны зардлын төсвийг баталсан. Нийтдээ 600,000 төгрөгийн төсвийг баталсан. ТУЗ-ийн хурлыг зохион байгуулах зардал нь 400,000 бусад зардал 200,000 гээд ингээд нийтдээ 600,000 төгрөгөөр 2022 оны ТУЗ-ийн зардлыг баталсан байсан. Хэлэлцсэн асуудлын тавд нь бол ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох асуудал байсан. Хот девелопмент компанийн ТУЗ нь бол нийтдээ 9 гишүүнтэй эндээ ердийн 6, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байдаг. ТУЗ-ийн ердийн гишүүд дээр болохоороо Солонго, Оргил, Батцэнгэл, Кунтуган, Лхамдэгд, Эрдэнэбаяр гэсэн хүмүүс сонгогдсон,

хараат бус гишүүд дээр болохоороо Баярмаа, Даваадор, Хосбаяр гэсэн ийм 3 хүн сонгогдоод нийтдээ 9 ТУЗ-ийн гишүүнийг томилсон байсан. ТУЗ-ийн дарга, гишүүд гүйцэтгэх захирал нар нь бол компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан хүмүүс байсан. ТУЗ-ийн дүгнэлтийн 2-т нь бол 2022 оны санхүүгийн тайлангийнхаа талаар тусгаж өгсөн байгаа. Пантер Мидланд Аудит компани нь 2022 оны жилийн эцсийн тайланд бол хараат бус санхүүгийн дүгнэлт гаргаж ажилласан. Хот Девелопмент компанийн 2022 оны санхүүгийн тайлан материаллаг алдаагүй үнэн зөв илэрхийлэгдсэн байна. Компани нь санхүүгийн тайлан тэнцэл ААНОАТ, ХХОАТ энэ тайлангуудаа цаг тухайд нь хүргүүлж, татварын байгууллагад хуульд заасан хугацаанд нь хүргүүлж ажиллаж байсан. Санхүүгийн үйл ажиллагаанд одоогоор гарсан томоохон гүйлгээ үл хөдлөх хөрөнгө худалдан авалт хийгдээгүй байна гэсэн ийм дүгнэлтийг бол гаргасан байгаа.

Одоо 2023 оны 2 сарын 8-ны өдөр ТУЗ-өөс гаргасан дүгнэлт байгаа. Ийм үйл ажиллагаа явуулж байсан юм байна, 2022 ондоо ТУЗ-ийн гишүүдээ сонгосон юм байна, санхүүгийн тайлан нь алдаагүй гарсан юм байна аа гээд. Энэ дүгнэлтийг бол ТУЗ-өөс гаргасан байгаа. ТУЗ-ийн дүгнэлтийг болохоор ХЭХ-аасаа баталдаг энэ ТУЗ-ийн дүгнэлт нь үнэн зөв юм уу үгүй юм уу гээд энэтэй холбоотойгоор ХЭХ-ын тогтоолын төслийг бэлдсэн байна.

Тогтоолын төслийг одоо уншиж танилцуулъя. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай нэгдүгээр тогтоолын төсөл Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн Хот Девелопмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тогтоох нь. Нэгдүгээрт Хот Девелопмент ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хангалттай гэж үзсүгэй. Хоёрт нь Хот девелопмент компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг баталсугай. Ийм агуулгаар тогтоолын төсөл бэлдсэн байгаа.

Хувьцаа эзэмшигчид нар энэ тогтоолын төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах хүсэлтэй байх юм бол одоо саналаа илэрхийлж болно. Хэрэв тогтоолын төслийг энэ чигээр нь баталъя эсвэл татгалзъя, түдгэлзье гэх юм болбол та бүхэнд тарааж өгсөн саналын хуудсан дээр зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэдгээ тэмдэглэгээ хийгээд ард нь гарын үсгээ зурах байгаа шүү. Хэрвээ татгалзсан байх юм болбол ямар шалтгаанаар татгалзаж байгаа юм тэрийгээ бас товчхон тайлбар биччихэж болно. Энэ болохоор та бүхэнд тарааж өгсөн саналын хуудасны хавсралт 5-ын нэг дэх асуудал байгаа. Тэмдэглэгээ хийхдээ нэмэх тэмдэг юм уу зөв тэмдэглэгээ хийж энэ дөрвөлжин дээр нь тэмдэглэнэ гэсэн үг.

Хувьцаа эзэмшигч Б.Чулуун-Эрдэнэ: Гарын үсэг ээ энд үү тэ?

Хурлын комиссын дарга Б.Номин: Гарын үсгээ тухай бүрт нь зураад баталгаажуулаад явах байгаа.

Хувьцаа эзэмшигч Б.Чулуун-Эрдэнэ: Хамгийн сүүлд хүмүүсийн санал авна биз дээ тэ? Тухайн үе бүрт тэмдэглээд явж байна уу?

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: Тухайн үе бүрт нь тэмдэглээд явчихвал амар байх. Яагаад гэхээр бид нарын хэлэлцэх асуудал чинь 11 асуудал байгаа. Тийм болохоор эргэж хараад явж байхаар цаг тухайд нь тэмдэглээд явчихвал хувьцаа эзэмшигчдэд амар байх.

Хэлэлцэх асуудал 2. Хот Девелопмент ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлттэй танилцах.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: Хэлэлцэх асуудлын хоёроо танилцуулах уу? Хот Девелопмент ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн яагаад бус аудитын дүгнэлттэй танилцах байгаа. Хараат бус аудитын дүгнэлт нь бол бичгээрээ гарсан энэ байна. За агуулгыг нь товч уншиж танилцуулбал Санхүүгийн тайлангууд нь материалын асуудлаар компанийн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл

болон мөнгөн гүйлгээ Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулж байна. Аудит хийхдээ аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн, уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага эсэхэд харуулсан. Бид Нягтлан бодогчийн ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс гаргасан мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон аудитын тухай Монгол Улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу компаниас хараат бус бөгөөд хууль болон нягтлан бодох бүртгэлийн ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Өөрөөр хэлэх юм болбол ямар нэгэн байдлаар хараат ажиллаагүй хараат бусаар энэ тайланг гаргасан гэдгээ ингээд аудитын дүгнэлтийнхээ үндэслэл хэсэгт бол оруулж өгсөн байсан. Тэгээд санхүүгийн тайлангийн аудитад аудитынхүлээх хариуцлагаа тусгаад өгчихсөн байсан. Ерөнхийд нь дүгнээд хэлэх юм болбол аудитын тайланг гаргахдаа хараат бусаар, үнэн зөв гаргасан гэдгээ Хот Девелопмент компанийн удирдлагад ирүүлсэн албан бичиг нь байгаа. Аудиторыг бол өнөөдрийн хуралдаа бол урьж оролцуулахаар ярьсан байсан боловч ажил нь давхацсан гэж тайлбар өгсөн. Тэгээд өнөөдрийн хуралд бол онлайнгаар оролцож чадаагүй байгаа.

Хурлын дарга Ч.Солонго: Дараа дараагийн ХЭХ дээр хөндлөнгийн аудитор бол шууд ТУЗ-ийн харьяалалтай байдаг учраас гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд дүнгээ тавиад, аудитаа хийгээд ХЭХ шаардлагатай бол ТУЗ-ийн орж ирж танилцуулгаа хийх ёстой байдаг.

Хувьцаа эзэмшигч Э.Баярбат: Цаашдаа тэгвэл тэгээд явъя.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: За тэгээд аудитын дүгнэлт бол ингэж гарсан байгаа. Энэхүү санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг батлах тухай тухай ХЭХ-ын тогтоолын төсөл саяын хэлэлцсэн асуудалтай холбоотойгоор ХЭХ-аас гарах тогтоолын төсөл нь энэ слайдад харагдаж байна. Санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлттэй танилцах тухай гэсэн тогтоол байгаа. Компанийн тухай хуулийн 62.1.15 дахь заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн Хот Девелопмент компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тогтоох нь. Нэгдүгээрт Хот Девелопмент компанийн 2022 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлттэй танилцан тооцсугай гэж оруулж ирж байгаа. Энэ яагаад танилцсанд тооцож байгаа гэж байгаа юм гэхээр санхүүгийн тайлан бол хараат бус гарах ёстой. Тэгэхээр ХЭХ-аас ямар нэгэн байдлаар батлахгүй ХЭХ-аар энэ асуудлыг ороод танилцсан шүү гэдгээ л бид нар баталгаажуулж тогтоол гаргаж байгаа гэсэн үг.

За энэ асуудал дээр саналаа хэлээд, нөгөө саналын хуудсаа бөглөөд яваарай. Энэ бол зүгээр төсөл байгаа. Тэгэхдээ саналын хуудсыг харж байгаад эцсийн байдлаар бол баталгаажна. Тооллогын комиссын дүнг үндэслэнэ гээд дандаа орчихсон байгаа.

Хэлэлцэх асуудал 3. Хот Девелопмент ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв батлах.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: За хэлэлцэх асуудлын 3 руу орж ирсэн. Хот Девелопмент компанийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө төсвийг батлах гэсэн ийм асуудал байгаа. За 2022 онд Хот Девелопмент компани ямар санхүүгийн байдалтай байсан юм бэ гэхээр 2022 оны санхүүгийн жилд бол идэвхтэй үйл ажиллагаа ерөөсөө явуулаагүй томоохон дүнтэй санхүүгийн ажил гүйлгээ хийгдээгүй байсан. 2022 ондоо ерөнхий удирдлагатай холбоотой л ерөнхийдөө зардал гарсан. Энэ нь бол 3,227,633 төгрөгийн алдагдалтай ажиллаад нийт хуримтлагдсан алдагдал нь 847,920,646 төгрөг хүрсэн байгаа. За 2023 онд компанийн бизнесийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, нийт хуримтлагдсан алдагдлын хэмжээг бууруулах, ашигт ажиллагааг бий болгох, цаашлаад хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилдаг компани болохын төлөө зорилго тавин ажиллахаар

төлөвлөсөн байгаа. Энэхүү зорилгынхоо хүрээнд бол дараах зорилтуудыг хэрэгжүүлж хийхээр төлөвлөсөн. Нэгдүгээрт гэх юм болбол компанийн дүрмийн өөрчлөлтөөр мэдээлэл технологи, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх гэсэн үйл ажиллагааны чиглэлийг одоогийн үйл ажиллагааны чиглэлдээ нэмж оруулна. Шаардлагагүй үйл ажиллагааны чиглэлийг хасна. За энэ шаардлагагүй үйл ажиллагааны чиглэл гэдэг бол дараа ахиад яригдана. 2-т нь компанийн дүрмийн өөрчлөлтөөр нийт гаргасан хувьцааны тоог нэмэгдүүлэх буюу хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргахаар төлөвлөсөн байна, 3-рт холбогдох хууль журмын хүрээнд нийт хувьцаа эзэмшигчдэдээ нэмж хувьцаа гаргахтай холбоотой шаардах эрхээ хэрэгжүүлэх бүрэн боломжоор хангах гэж байгаа. Энэ энэ асуудлыг бас 2023 ондоо хийж хэрэгжүүлэх нь байна. 4-рт хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах замаар стратегийн хөрөнгө оруулагчаас хөрөнгө татан төвлөрүүлж хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлнэ, 5-д нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тусгай зөвшөөрлийн хүсэлт гаргах энэ ажлыг хийхээр төлөвлөсөн байна 6-д нь хүний нөөцийн бүтэц бүрэлдэхүүнийг тодорхойлох чадварлаг боловсон хүчнээр багаа бүрдүүлнэ, 7-д нь шинэ төсөл хөтөлбөрийг боловсруулна, хэрэгжүүлнэ, 8-д нь хувьцаа эзэмшигчид компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээ мэдээллийг нээлттэй, ил тод, түргэн шуурхай хүргэх дотоод тогтолцоог бий болгохоор зорин ажиллаж байна. За ингээд 2023 оны Хот Девелопмент компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө төсвийг батлах ХЭХ-ын тогтоолын төсөл слайданд гарч ирсэн тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт Тооллогын комиссын дүнг үндэслэн Хот Девелопмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тогтоох нь. 1-рт Хот Девелопмент ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралт нэгээр баталсугай. Хавсралт нэг нь болохоороо одоо бидний сая ярилцсан энэ зорилтуудыгаа хавсралтаар оруулж өгчихсөн байгаа. 2-т нь Хот Девелопмент ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хөрөнгийн хэмжээг хоёр тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн баталсугай. Хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргахтай холбоотойгоор л хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдэх нь байна аа.

Хувьцаа эзэмшигч Ч.Солонго: Энэ дээр нь тодруулга байгаа. Толгойг нь харах юм бол тогтоолын толгой болохоор төсвийг батлах гэж орж ирж байгаа 2023 оны. Ерөнхийдөө дараа жилээс яг төсөв төлөвлөгөөгөө батлаад хэчнээн хэмжээний үр ашигтай, орлоготой ажиллах юм, хэчнээн хэмжээний зардал гарах юм. Тэр орлого ашгаа олохын тулд ингээд зардлын бүтцээр нь ч юм уу үр ашгаа нь тооцоолоод бүгдийг нь гаргаад ирэх ёстой. Гэхдээ одоохондоо нөгөө удирдлагууд томилогдоогүй байгаа. Ерөнхий төсөв орж ирээгүй байгаа учраас яг дүн хэлэх хэцүү байгаа юм л даа. Энэ компани цаашаагаа хөгжөөд төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхээс гадна бүтэн том зургаар нь тогтолцоо маань авах ёстой учраас одоохондоо төсөв гэдгийгээ ерөнхийдөө санхүүгийн үзүүлэлт буюу 2 дахь хэсэг хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх гэдэг утгаар нь оруулчихсан байж байгаа юм.

Хувьцаа эзэмшигч Б.Чулуун-Эрдэнэ: Би нэг юм тодруулчих уу. Одоо алдагдал нь 847,000,000 төгрөг байгаад байгаа шүү дээ. Тэр чинь болохоор хуримтлагдсан алдагдал нь компанийн өөрийн хөрөнгө болох уу? Хасах хэсэг дээр ороод. Тэгэхээр хоёр тэрбум нэмэгдүүлчихээр чинь үндсэн хөрөнгө маань хасагдаад тэрбум хэдэн зуун төгрөг болох уу?

Хувьцаа эзэмшигч Ч.Солонго: Хувь нийлүүлсэн хөрөнгө, эздийн өмч гэдгийг харуулсан компанийн балансын санхүүгийн хэсгийг гаргаад ярилцъя. Хуримтлагдсан ашиг алдагдал бол угаасаа тухайн жил жилийн үйл ажиллагааны орлого ашгийн зөрүүгээр компани үйл ажиллагаа явуулаагүй учраас зардлууд нь хуримтлагдаад алдагдал болоод байна гэсэн үг. Нийт эздийн өмч дотор хэд хэдэн бүрэлдэхүүн хэсэг байдаг. Хувьцаа, хувь нийлүүлсэн хөрөнгө г.м. Тэрэн дээр 2021 оны 1 сард компанийн өр төлбөрийг өмч рүү бүртгэсэн СЗХ-ны зөвшөөрөлтэй бүртгэл байгаа. Тэгэхээр өмч буюу хувьцааны нийт өмч маань 840 хэд гээд бараг алдагдлынхаа хэмжээтэй дүйцэж орж ирж байгаа.

Хувьцаа эзэмшигч Б.Чулуун-Эрдэнэ: Өмч рүү бүртгэхээр яана гэсэн үг вэ?

Хувьцаа эзэмшигч Ч.Солонго: Компанийн өмч гэсэн үг байхгүй юу. Хувьцааны нэг өмч нь тэр тухайн ХК капитал гэсэн үг байхгүй юу. Өмч гэсэн хэсэгт байдаг. Тэгээд алдагдалтайгаа нийлээд оффсет болоод нэттлэгдэнэ гэсэн үг. Тэгээд цэвэршээд нийт балансын дүн чинь 15,000,000 орчим төгрөгтэй тэнцэж байгаа гэсэн үг. Тэгэхээр одоо өөрөөр хэлбэл хоёр тэрбумаар хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлнэ гэдэг чинь алдагдалд нөлөөлөхгүй. Хувь нийлүүлсэн хөрөнгө 847,000,000 гэж харагдаж байгаа биз. Эздийн өмчийн бүтэц нь өмч байна, халаасны хувьцаа байна, нэмж төлөгдсөн капитал байна тэгээд дахин үнэлгээний нэмэгдэл орж ирдэг энэ нь болохоор биет бус хөрөнгө дээр бол программ хангамж дээр нэмэлт орж ирж байгаа. Жил болгон үнээ нэмэгдүүлээд байж болно гэсэн энүүгээр өөрийнхөө эздийн өмчийг нэмэгдүүлж болдог. За дараагийнх нь бол ерөнхийдөө том бүтэц нь бол нийт хуримтлагдсан ашиг алдагдал гэж орж ирдэг. Ийм бүрэлдэхүүнээс энэ эздийн өмч гэдэг балансын зүүн талын доод булан маань ерөнхийдөө гарч ирдэг. Нийт хөрөнгөөс өр төлбөрийг хасаад цэвэр хөрөнгө буюу эздийн өмч гарч ирж байгаа юм. Тэгэнгүүт 443,000,000 гэдэг дүн маань өөр хэлбэл хувь нийлүүлсэн хөрөнгө буюу дээд өр төлбөрөөсөө СЗХ-ны зөвшөөрөл тогтоолын дагуу ХК учраас зөвшөөрөл аваад байгаа юм. Өмч рүү өөрөөр хэлбэл энэ компанид шилжүүлээд 2021 оны 1 сард зөвшөөрөл аваад бүртгэсэн байгаа юм. Тэгэнгүүт алдагдалд дор 847,000,000 байгаа биз. Тэгэнгүүт эзний өмчийн зөрүү яг цэвэршүүлсэн дүнгээрээ 915,000 төгрөг гэсэн үг. Өөрөөр хэлбэл энэ 2 нэмж хасагдаад ингээд цэвэршээд ороод ирчхэж байгаа. Тэгээд балансынх нь нийт дүн бол 15.9 сая төгрөгийн үнэтэй байгаа. Тэгэнгүүт алдагдлынхаа хэмжээг хасах юм бол эздийн өмчийнх нь дүн нь хоёр тэрбумаар хэвээрээ байгаа. Хоёр тэрбумаар нэмэгдүүлэхэд 2.8 тэрбум хувь нийлүүлсэн хөрөнгө гэж үзнэ.

Хувьцаа эзэмшигч Э.Баярбат: Зөв зөв.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: За энэ саяын тогтоол байна. Энэ хавсралтад болохоор түрүүн ярилцсан 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө ярьсан 8 заалтынхаа дагуу батлагдахаар төлөвлөгдсөн байна аа

Хувьцаа эзэмшигч Ч.Солонго: Төсөв дээр харин яах вэ? 2023 оны төсөв гэдэг маань хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх асуудлаар зөвхөн хязгаарлагдахгүй байгаа. Үйл ажиллагааны төлөвлөгөө, тухайн үйл ажиллагаа явуулахтай холбоотой ямар зардал, ямар орлого ашиг олох юм гэдэг юм байх ёстой.

Хувьцаа эзэмшигч Ч.Солонго: Одоо 3 хоногийн дотор СЗХ, МХБ-д хурлын материалуудаа гаргаж өгнө.

Хувьцаа эзэмшигч Э.Баярбат: Төсвийг хавсралтаар оруулъя.

Хувьцаа эзэмшигч Б.Чулуун-Эрдэнэ: Тэгье.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: За тэгвэл энэ тогтоолын төсөлд хавсралтаар төсөв оруулж ирэхээр тогтлоо. Энийг хурлын тэмдэглэлд тусгаад тогтоолдоо өөрчлөлт оруулаад явъя.

Хэлэлцэх асуудал 4. Хот Девелопмент ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг шинээр сонгох, томилох.

Хэлэлцэх асуудал 4 нь бол Хот Девелопмент ХК-ийн Тузийн ердийн болон хараат бус гишүүнийг шинээр сонгох томилох асуудал байна. За ердийн гишүүдэд нэр дэвшигчид бол Э.Баярбат, Ч.Солонго, Б.Чулуунсүх, Л.Алтангэрэл, С.Отгонсайхан, М.Дөлгөөн. Хараат бус гишүүдэд нэр дэвшигчид нь Э.Эрдэнэбаатар Д.Лхамдэгд, Э.Ганбаатар Б.Чулуун-эрдэнэ гэсэн 10 хүн нэр дэвшчихсэн байгаа. Энэ 10 хүнээсээ бид нар санал өгөөд 9 Тузийн гишүүнтэй болохоор байгаа 6 нь хараат 3 нь хараат бус гишүүн байна. Энэ ТУЗ-ийн гишүүдийг сонгохтой холбоотойгоор санал асуулгын хуудас бөглөхдөө

ердийн биш кумулятив аргыг сонгож бөглөх байгаа. Тайлбар нь хавсралт 4 дээр байгаа. Хавсралтад 4-ийг харах юм бол кумулятив аргаар санал өгөх талаар тайлбарласан.

Хувьцаа эзэмшигч Ч.Солонго: Хүмүүстээ уншиж биш чиглүүлээд тайлбарлаад өгчих үү.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: Кумулятив аргаар санал өгөхдөө хувьцаа эзэмшигчид нь эзэмшиж буй хувьцааныхаа тоог ТУЗ-ийн 9 гишүүнийхээ тоогоор үржүүлнэ гэсэн үг 2,000,000 хувьцаа эзэмшиж байгаа хүн бол 18,000,000 саналтай болно гэсэн үг 18,000,000 саналаа энэ 10 гишүүдийнхээ алинд нь ч өгсөн болно. Өөрийнхөө дураар хуваагаад өгөх нь байна шүү дээ. 18,000,000 саналыг нь нэг хүнд өгчихсөн ч болно. Эсвэл 9 гишүүддээ тэгш хуваагаад бас хуваарилаад өгсөн ч болно гэсэн үг. Одоо та бүхний эзэмшиж байгаа хувьцааны тоо бол 2,813,625, 2,794,271 байгаа. Энийгээ 9-өөр үржүүлнэ гэсэн үг. Тэгээд ТУЗ-д сонгогдох гэж байгаа нэр дэвшиж байгаа хүмүүстээ саналаа өгнө. Саналаа хавсралт 6 дээр өгнө гэсэн үг. Нэр дэвшигчид өгөх саналын тоо гээд байгаа.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: За 6 ердийн гишүүн, 3 хараат гишүүд хараат бус гишүүдээ бол томилох энэ тогтоолын төсөл энэ байна. Компанийн тухай хуулийн 62.1.7 дахь заалт Тооллогын комиссын дүнг үндэслэн Хот Девелопмент ХК-ийн ХЭХ-аас тогтоох нь гээд та бүгдийн өгсөн саналыг үндэслэн гишүүдийн нэрсэд өөрчлөлт орно.

Хувьцаа эзэмшигч Э.Баярбат: За энийгээ хураалгачих уу.

Хэлэлцэх асуудал 5. Хот Девелопмент ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийн цалин, үйл ажиллагааны зардлын төсвийг батлах тухай.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: Тав дахь асуудал нь ТУЗ-ийн хараат бус гишүүдийн цалин ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсвийг батлах тухай асуудал байгаа. ТУЗ-ийн хараат бус гишүүний цалинг бол 100,000 төгрөгөөр ТУЗ-ийн 2023 оны зардлын төсвийг 600,000 төгрөгөөр тус тус тогтоохоор төсөл орж ирсэн байна. Хараат гишүүдэд бол одоохондоо цалин байхгүй.

Хувьцаа эзэмшигч Э.Баярбат: 2023 ТУЗ-ийн зардлыг нэг 600,000-аар төлөвлөсөн байна. Энэ үнэд багтах уу?

Хувьцаа эзэмшигч Ч.Солонго: Энэ болбол зөвхөн ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой тул 600,000 байх боломжтой. Энэ ихсэх бол асуудалгүй.

Хэлэлцэх асуудал 6. Хот Девелопмент ХК-ийн ТУЗ-өөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэртэй танилцах.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: За хэлэлцэх асуудал 6 руу орж ирсэн. Хот Девелопмент ХК-ийн ТУЗ-өөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэртэй танилцаад ХЭХ-аараа батлах байгаа. ТУЗ-ийн тогтоол бол 2023 оны 1 сарын 18-ны өдөр гарсан 23/03 гэсэн дугаартай тогтоол байгаа. Энэхүү тогтоолыг уншиж танилцуулъя. Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5, 46.6 болон Хот Девелопмент ХК-ийн ТУЗ-ийн гишүүдийн 2023 оны 1 сарын 17-ны өдрийн эцнээ санал хураалтыг үндэслэн тогтоох нь нэгдүгээрт Хот Девелопмент ХК нь 2022 онд алдагдалтай ажилласан тул хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай 2-т Ногдол ашиг хуваарилахгүй байх үндэслэлийг ХЭХ-д тайлагнахыг ТУЗ-ийн даргад үүрэг болгосугай гэсэн ийм тогтоол гарсан байгаа. 2022 онд идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй, алдагдалтай ажилласан болохоор ТУЗ-өөс ноогдол ашиг тараахгүй гэсэн тогтоол гарсан. За энэтэй холбоотойгоор ХЭХ-ын тогтоолын төсөл нь энэ байна. Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн

46.1 62 дугаар зүйлийн 62.1.15 дахь заалт Тооллогын комиссын дүнг үндэслэн Хот Девелопмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдийг ээлжит хурлаас тогтоох нь. Нэгдүгээрт Хот Девелопмент ХК-ийн ТУЗ-өөс гаргасан 2022 оны тайлант хугацаанд үйл ажиллагаа явуулаагүй алдагдалтай ажилласан тул ногдол ашиг тараахгүй байх тухай шийдвэрийг баталсугай. Ийм агуулга бүхий тогтоолын төсөл байна аа.

Хувьцаа эзэмшигч Э.Баярбат: Ногдол ашгийг бол ашигтай ажилласан тохиолдолд хуваарилна. ТУЗ-аас дүгнэлт гаргаад гаргасан дүгнэлтийг нь ХЭХ-аараа батлаад явна.

Хэлэлцэх асуудал 7. Хот Девелопмент ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өсгөх, хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргахыг батлах тухай.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: Хэлэлцэх асуудал 7. Хот Девелопмент ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өсгөх, хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргахыг батлах тухай. Занн Корпорейшн Монголиа ХХК-аас Хот Девелопмент ХК-ийн хаалттай хүрээнд гаргаж байгаа хувьцааг худалдан авах саналаа бидэнд ирүүлсэн. Үүнийг слайданд харуулъя. Одоо тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өсгөхийг батлах. Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйл 55 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.13 62.1.15 дахь заалт 83-ын 8 дахь хэсэг, 87 дугаар зүйл, 88 дугаар зүйл, 89 дүгээр зүйл, Тооллогын комиссын дүнг үндэслэн Хот Девелопмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тогтоох нь. Нэгдүгээрт нэг бүр нь 100 төгрөгийг нэрлэсэн үнэтэй хорин сая ширхэг энгийн хувьцааг нэмж гаргасугай. Хувьцааны үнэлгээн дээр бол СЗХ болон Хөрөнгийн биржтэй зөвшилцөөд нэрлэсэн үнээрээ буюу 100 төгрөгөөр гаргах нь зүйтэй юм байна гэсэн шийдэлд хүрсэн байгаа. 2-т нь хувьцаа нэмж гаргаж байгаатай холбогдуулан компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хоёр тэрбум төгрөгөөр нэмэгдүүлээд 2,847,005,400 төгрөг байхаар тогтсугай. Одоо компанийн дүрэм дээр явж байгаа хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ бол 847,005,400 байгаа. Энэ дээрээ хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргаж байгаатай холбоотойгоор хоёр тэрбум төгрөгөөр хөрөнгийн хэмжээгээ өсгөхөд 2,847,005,400 болж байгаа гэсэн үг. 3-т нь нэмж гаргаж буй хувьцааг компанийн хувьцаа эзэмшигч нар тэргүүн ээлжид худалдан авах эрхээ Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу хэрэгжүүлсний дараа үлдэх хэсгийг Занн Корпорейшн Монголиа ХХК-аас ирүүлсэн хаалттай хүрээнд хувьцаа худалдан авах захиалгын дагуу худалдахыг зөвшөөрсүгэй. Энэ тэргүүн ээлжид худалдан авах эрх гэдэг нь болохоороо компанийн хувьцаа эзэмшигч бол Компанийн тухай хуульд заасны дагуу компани хувьцаа гаргаж байгаа эсвэл бусад хувьцаа эзэмшигч ямар нэгэн байдлаар хувьцаагаа худалдаж байгаа тохиолдолд компанид хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй байдаг. Энэ эрхийнхээ хүрээнд компанийн тухай хуульд заасны дагуу компанийнхаа хувьцаа эзэмшигч нарт эрхийг нь олгох, тэргүүн ээлжид худалдаж авах хуулийн хугацаа нь ажлын гуч хоног байгаа. Энэхүү гуч хоногоо хүлээгээд тэр гуч хоногийн дотор хувьцааг худалдан авах хүсэлтээ илэрхийлсэн хүн байх юм бол хувьцааг бол худалдаж болно гэсэн үг. Гэхдээ энэ бол хорин сая ширхэг хувьцааг тэр чигт нь нэг хүнд худалдана гэсэн үг бол биш. Одоо өөрийнхөө хувь эзэмшиж байгаа хувьцаандаа хувь тэнцүүлээд худалдаж авна гэсэн үг. Ажлын гуч хоногийн дотор ямар нэгэн байдлаар хүсэлтээ илэрхийлээгүй байх юм болбол хорин сая ширхэг хувьцаагаа Занн Корпорейшн Монголиа руу шилжүүлнэ ээ гэсэн ийм агуулгатай байгаа. За 4-т нь Хот Девелопмент ХК-аас дараах төрөл, үнэ, тоо ширхэг бүхий энгийн хувьцааг хаалттай хүрээнд Занн Корпорейшн Монголиа ХХК-д эзэмшүүлсүгэй. Хувьцааны төрөл нь бол энгийн хувьцаа. Шилжүүлэх хувьцааны тоо ширхэг бол одоогийн байдлаар тодорхой биш яагаад гэхээр нөгөө хувьцаа эзэмшигч нь тэргүүн ээлжид хувьцаа худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэхээс шалтгаалаад тухайн үедээ бол шийдэгдээд явна. Хаалттайгаар нэмж гаргах нэгж хувьцааны үнэ бол 100 төгрөг, хувьцааны нэрлэсэн үнэ нь бол компанийн дүрэмдээ заасны дагуу бол 100 төгрөг байгаа. Энүүгээрээ явж байгаа. За тавд нь Хот Девелопмент ХК нь хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргахтай холбогдуулан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг гүйцэтгэх захирал зөвшөөрсүгэй. Компанийн тухай хуулийн

холбогдох заалтыг гаргаж ирээд харуулъя.

Хувьцаа эзэмшигч Б.Чулуун-Эрдэнэ: Томоохон гэрээ болон ийм нөхцөлөөс давсан гэсэн юм байдаг тэ.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: Тийм. Их хэмжээний хэлцэл бол активын 25 хувиас давсан байвал их хэмжээний хэлцэл болно. Сонирхлын зөрчилтэй хэлцэл бол гэрээний нөгөө талтай холбоотой. Компанийн энгийн хувьцааны хорь буюу түүнээс дээш хувийг дангаараа эсхүл бол түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтан түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай доор дурдсан харилцаанд оролцсон бол компанитай эсвэл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно гээд Компанийн тухай хуулийн 89.1-д заасан байгаа. 89.1.1-д нь хэлцлийн нөгөө тал эсвэл хэлцэл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа. Одоо хуралд оролцож байгаа 3 хувьцаа эзэмшигчийн Баярбат захирлын эзэмшиж байгаа хувьцаа 33 хувьтай байгаа. Тэгэхээр 20 хувиасаа бол давчихсан. За тэгээд компанийн хувьцааг худалдаж авах гэж байгаа Занн Корпорейшн Монголиа компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаа. Тийм болохоор энэ тохиолдолд Баярбат захирал бол сонирхлын зөрчилтэй этгээд болж байна гэж үзээд энэхүү заалтыг бол тогтоолын төсөлд оруулж өгсөн. Нэг юм тодруулж хэлэхэд одоо энэ сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах эрх олгосон тогтоолын төсөлд Баярбат захирал ямар нэг байдлаар санал өгөхгүй. Үлдсэн 2 хувьцаа эзэмшигч буюу Ч.Солонго, Б.Чулуун-Эрдэнэ нар саналаа өгөх байгаа шүү. За зургаадугаарт нь бол Хот Девелопмент ХК-ийн хувьцааг хувьцаа эзэмшигч нар болон Занн Корпорейшн Монголиа ХХК худалдан авахтай холбогдуулан талуудын хооронд байгуулах хувьцаа худалдан худалдан авах гэрээ, эрх шилжүүлэх гэрээ байгуулах болон хувьцааг шилжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн бусад гэрээнүүд тухайлах юм бол ҮЦК нь арилжааны банк зэрэг байгууллагууд болон бусад үйлчилгээ үзүүлэгч нартай байгуулах гэрээнд гарын үсэг зурах эрхийг гүйцэтгэх захирал олгосугай. 7-д нь Хот Девелопмент ХК хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргаж буйтай холбогдуулан компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийг тусдаа тогтоолоор баталж байгаа. Нэмэлт өөрчлөлт орсон дүрэм нь төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл гарч улсын бүртгэлд бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр болно гэсэн. 8-д нь Хот Девелопмент ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдэж буйтай холбоотойгоор МХБ болон СЗХ-нд холбогдох журмын дагуу мэдэгдэж, зөвшөөрөл авах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай. 9-д нь Хот Девелопмент ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдэж үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсныг МХБ болон СЗХ зөвшөөрөн, нэмэлт хувьцаа бүртгэгдсэний дараа Компанийн дүрэмд орсон нэмэлт өөрчлөлтийг УБЕГ хандаж бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захиралд даалгасугай. За энэ тогтоолын төсөлтэй холбоотой асууж тодруулах зүйл байвал асууж болно. Энэ нь нэмж хувьцаа гаргахтай холбоотойгоор бий болсон, үүсгэсэн хөрөнгөөр ямар төсөл хэрэгжүүлэх юм бэ гэхээр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрлийг СЗХ-оос авах, одоохондоо ийм төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ ээ гэсэн байдалтай явж байна.

Хэлэлцэх асуудал 8. Хот Девелопмент ХК-ийн үйл ажиллагааны чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай.

За хэлэлцэх асуудлын 8 руу орж ирсэн байна. Хот Девелопмент ХК-ийн үйл ажиллагааны чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай. 2023 оны төлөвлөгөө батлахдаа чиглэлд нь нэмэлт өөрчлөлт оруулна гэж ярьсан. Тэрэнтэй холбоотойгоор хэлэлцэх асуудал дээр орж ирж байна аа гэсэн үг. За хурлын тогтоолынхоо төслийг уншиж танилцуулъя. Үйл ажиллагааны чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулахыг батлах тухай Компанийн тухай хуулийн 62-дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт Тооллогын комиссын дүнг үндэслэн Хот Девелопмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тогтоох нь нэгдүгээрт Хот Девелемент ХК-ийн үйл ажиллагааны чиглэлд дараах чиглэлийг нэмсүгэй. 1.1-т нь Мэдээлэл технологийн үйл ажиллагаа 1.2-т нь төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх. За 2-т нь УБЕГ-ын

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас хуулийн этгээдийн Үйл ажиллагааны чиглэлийн нэршилд өөрчлөлт оруулан батлагдсантай холбогдуулан тус компанийн дүрмийн нэгийн 4-ийн б-д заасан гадаад худалдаа гэсэн чиглэлийг хасаад оронд нь төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа гэж өөрчлөн тусгасугай. Хуучин компанийн дүрэм дээр болохоороо гадаад худалдаа, худалдааны зуучлал гэж явдаг байсан аа энийг нь болохоор улсын бүртгэлээс чиглэлийнх нь нэршлийг нь өөрчлөгдсөнтэй холбоотой өөрчлөлт орж байна аа гэсэн үг. Гадаад худалдаа хасагдаад төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдан авч ирж байна. 3-т нь Хот Девелопмент ХК-ийн үйл ажиллагааны чиглэлд орсон өөрчлөлтийг компанийн дүрэмд тусдаа тогтоолоор батлах бөгөөд нэмэлт өөрчлөлт орсон дүрэм нь төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл гарч улсын бүртгэлд бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр болно гэсэн ийм агуулгатай хурлын тогтоол байна аа.

Хувьцаа эзэмшигч Э.Баярбат: Мэдээлэл технологи, төсөл хөтөлбөр 2 нэмж орж ирээд дүрэм төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл гарч гэдэг нь бид нар одоо жишээ нь санхүүгийн зохицуулахаас мэдээлэл технологийн үйл ажиллагааных нь зөвшөөрлийг авсан нь баталгаажиж байж хүчинтэй болох уу.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: Энэ мэдээлэл технологийн үйл ажиллагаа төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх 2 бол тусгай зөвшөөрөл шаарддаггүй үйл ажиллагаа байгаа. Гэхдээ бид нар хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргаад, компанийн дүрэмд өөрчлөлт орж байгаатай холбоотойгоор СЗХ-оос зөвшөөрөл авсны дараа улсын бүртгэлд бүртгүүлэхээр төлөвлөсөн.

Хувьцаа эзэмшигч Ч.Солонго: Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрөл бол тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа байгаа. Энэ тусгай зөвшөөрлөө авахын тулд суурь үйл ажиллагааны чиглэл байгаа.

Хэлэлцэх асуудал 9. Хот Девелопмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: За хэлэлцэх асуудлын 9 нь бол Хот Девелопмент ХК-ийн ХЭХ-д оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олгохоор хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх тухай. Энэ асуудлыг хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхоороо шийдвэрлэдэг байгаа. За Компанийн тухай хуулийн 38.1-т болохоороо компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь компаниас нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг өөрийн энгийн хувьцаатай тоо хувь тэнцүүлэн тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй. 38. 2-т нь энэ хуулийн 62.1.3-т заасны дагуу хувьцааг нэмж гаргах шийдвэр гаргах үед нэмж гаргаж байгаа хувьцааны тоо, үнэ, хувьцаа эзэмшигч бүрийн худалдан авч болох хугацааны тоо, төлбөр хийх хугацаа, журам зэргийг заасан мэдэгдлийг энгийн хувьцаа эзэмшигч бүрд ХЭХ-ын зар хүргэдэг журмаар хүргүүлнэ. Өөрөөр хэлэх юм болбол нийтэд мэдээлнэ гэсэн үг. 38.3-т нь хувьцаа эзэмшигч тэргүүн ээлжид худалдан авах эрхээр хувьцааг худалдан авах тухай саналаа ХЭХ-ын шийдвэр гарснаас хойш ажлын гуч өдрийн дотор ирүүлнэ гээд Компанийн тухай хуулийн холбогдох заалтууд нь мөн байна. За энэтэй холбоотойгоор хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх тухай гэсэн хурлын тогтоолын төсөл бэлэн болсон. Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл, Тооллогын комиссын дүнг үндэслэн Хот Девелопмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тогтоох нь. Нэгдүгээрт Хот Девелопмент ХК нь хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргаж буйтай холбогдуулан ХЭХ-д оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг тус компанийн хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхээр тогтсугай. Энэ эрхийг ХЭХ-аараа эдлүүлэхгүй байхаар бас тогтож болно. Дийлэнх олонхоороо шийдвэрлэх юм болбол. Хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг хамгаалах үүднээс энэ хувьд эрхээ бол олгоё оо л гэж тогтоолын төсөлд оруулсан байгаа юм. Та бүхэн саналаа өгч болно. Санал байхгүй бол дараагийн асуудал руу орох уу?

Хэлэлцэх асуудал 10. Хот Девелопмент ХК нэмж хувьцаа гаргахтай холбогдуулан шаардах эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай.

Хот Девелопмент ХК нэмж хувьцаа гаргахтай холбогдуулан шаардах эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай. Компанийн тухай хуулийн зүйл заалтууд нь 54.1.т нь энэ хуулийн 53-дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх үүсгэсэн шийдвэр гаргах тохиолдол бүрт компани нь энэ эрх, түүнийг хэрэгжүүлэх журмын талаар ХЭХ-ын зар хүрэх журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх үүрэгтэй. Өөрөөр хэлэх юм болбол хувьцаа эзэмшигч нь компаниас өөрийнхөө эзэмшиж байгаа хувьцааг худалдан аваач ээ гэж шаардах эрхтэй. Тэр эрхийг хэрэгжүүлэх үедээ журам гаргана. 54.2-т нь өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтээ хувьцаа эзэмшигч нь эргүүлж авах тухай шаардлагыг бичгээр гаргах бөгөөд эцэг, эхийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эргүүлэн худалдан авахыг шаардаж байгаа хувьцааны тоо төрлийг заана. Ажлын 30 хоногийн дотор мэдэгдэл бөглөнө гэсэн үг. Энийг тэгэхдээ ТУЗ-ийн хурлаар батална. Компанийн тухай хуулийн заалтууд нь ийм байгаа. ХЭХ-аас гарах хурлын тогтоолын төсөл нь шаардах эрхийг хэрэгжүүлэх тухай гээд Компанийн тухай хуулийн 17-дугаар зүйлийн 17.2 дахь заалт, 53 дугаар зүйл, 54 дүгээр зүйл болон Тооллогын комиссын дүнг үндэслэн “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тогтоох нь Хот Девелопмент ХК нь хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргаж компанийн үйл ажиллагааны чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулсныг үндэслэн Хот Девелопмент ХК-ийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж буйтай холбогдуулан 2023 оны 2 сарын 8-ны өдрийн ХЭХ-д оролцсон хувьцаа эзэмшигчид нь хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэхээр тогтов.

Хэлэлцэх асуудал 11. Хот Девелопмент ХК-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: За ингээд хэлэлцэх асуудлын хамгийн сүүлийн асуудал нь байна. 11 дэх асуудал. Хот Девелопмент ХК-ийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах тухай за дүрэмдээ болохоороо гол нэмэлт өөрчлөлт орж байгаа заалтуудыг нь слайдандаа харуулсан байгаа. Компани нь дараах чиглэлээр бизнесийн үйл ажиллагаагаа явуулна гээд. а-д нь бизнесийн зөвлөгөө өгөх б-д нь төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа с-д нь мэдээлэл технологийн үйл ажиллагаа d-д төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх. Өмнө нь үйл ажиллагааны чиглэл нь 2 байсан бол одоо 4 болж өөрчлөгдсөн гэсэн үг. За хоёрын нэг дэх заалтад бас өөрчлөлт орсон байгаа. Компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 28,470,054 ширхэг энгийн хувьцаа гаргасан бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгө нь 2,847,005,400 төгрөг болно.

За дүрмийн нэмэлт өөрчлөлтийг тусгасан тухай тогтоолын төслийг танилцуулъя. Компанийн тухай хуулийн 62-дугаар зүйлийн 62.1.1 болон 62.1.5 дахь заалтууд болон тооллогын комиссын дүнг үндэслэн Хот Девелопмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас тогтоох нь. Нэгдүгээрт Хот Девелопмент ХК нь хаалттай хүрээнд нэг бүрийн 100 төгрөгийг нэрлэсэн үнэтэй 20,000,000 ширхэг энгийн хувьцааг нэмж гаргаж компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь хоёр тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 2,497,005,400 төгрөг байхаар тогтсоныг, компанийн үйл ажиллагааны чиглэлд мэдээлэл технологийн үйл ажиллагаа төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа нэмэгдсэнийг, компанийн гадаад худалдаа гэсэн чиглэл хасагдаж төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа гэх үйл ажиллагаа нэмэгдсэнийг тус тус үндэслэн Хот Девелопмент ХК-ийн дүрэмд холбогдох нэмэлт өөрчлөлт оруулан хавсралт нэг ёсоор баталсугай. Нэмэлт өөрчлөлт орсон дүрэм нь төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөл гарч улсын бүртгэлд бүртгэгдсэнээр хүчин төгөлдөр болно оо гэдэг ийм дүрмийг батлах тогтоолын төсөл байна. Өмнө нь гарсан ХЭХ-ын шийдвэртэйгээ холбоотойгоор л бүгдийг нь базаад дүрмээ нэмэлт өөрчлөлт оруулаад баталж байна гэсэн үг.

Хувьцаа эзэмшигч Ч.Солонго: Өмнө ярилцсан асуудалтай холбоотой санал хэлье. Хөрөнгө

оруулалт авах 2 тэрбум төгрөгөө жоохон нэмэх саналтай байна. Тусгай зөвшөөрөл авахад хувь нийлүүлсэн хөрөнгө нь 2 тэрбумаас доошгүй байна гээд хуулин дээр байгаа. Төсөлд хамгийн бага үнийн дүнг оруулсан байна. Ядаж 2 тэрбум 50 сая болгох саналтай байна. Энэ бол хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл тул хувьцаа эзэмшигчид одоо ярилцаад санал байвал нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Хувьцаа эзэмшигч Б.Чулуун-Эрдэнэ: Жоохон нэмсэн нь дээр байхаа.

Хувьцаа эзэмшигч Ч.Солонго: Хуулин дээр бол 2 тэрбумаас доошгүй гэж байгаа.

Хувьцаа эзэмшигчид: Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмгдүүлэх хэмжээг 2,050,000,000 төгрөг болгож, нэмж гаргах хувьцааны тоо ширхэгийг 20,500,000 болгохыг ярилцан зөвшилцөж шийдвэрлэв. Тогтоолын төслүүдэд зохих өөрчлөлтийг оруулахыг Хурлын дарга болон Хурал зохион байгуулах комиссын дарга нарт даалгая.

Хурал зохион байгуулах комиссын дарга Б.Номин: Өөр нэмэлт асуулт, санал хүсэлт үгүй бол ингээд өнөөдрийн хэлэлцэх асуудал дууссан байна. Завсарлах явцад тооллогын комисс хувьцаа эзэмшигчдийн саналыг тоолж, завсарлагааны дараа дүнгээ танилцуулах байгаа.

Тооллогын комиссын дарга Г.Ганхүү: Хурал завсарлах явцад тооллогын комисс хуралдаж хувьцаа эзэмшигч нарын саналын хуудсын дүнг нэгтгэж тогтоол гаргав. Санал хураалтын нэгдсэн дүнгийн тухай “Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлаар санал өгсөн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналыг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ** нь:

“Хот Девелопмент” ХК-ийн саналын эрх бүхий нийт 8,470,054 ширхэг хувьцаанаас 99.43% буюу 8,421,521 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3 хувьцаа эзэмшигч хуралд оролцсон.

Хурлаар дараах асуудлуудыг ердийн аргаар санал хураан шийдвэрлэв.

1. Хот Девелопмент ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 8,421,521 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
8,421,521	100%	0	0%	0	0%

2. Хот Девелопмент ХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлттэй танилцах асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 8,421,521 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн. Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0%

түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
8,421,521	100%	0	0%	0	0%

3. Хот Девелопмент ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв батлах асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 8,421,521 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.
Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
8,421,521	100%	0	0%	0	0%

4. Хот Девелопмент ХК-ийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг шинээр сонгох, томилох асуудалд кумулятив аргаар дараах байдлаар тус тус санал авч доорх нэр дэвшигчид ТУЗ-ийн гишүүдээр сонгогдов. Үүнд:

Ердийн гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн ердийн гишүүдэд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Э.Баярбат	11.11%	8,421,521
2	Ч.Солонго	11.11%	8,421,521
3	Л.Алтангэрэл	11.11%	8,421,521
4	Б.Чулуунсүх	11.11%	8,421,521
5	С.Отгонсайхан	11.11%	8,421,521
6	М.Дөлгөөн	11.11%	8,421,521

Хараат бус гишүүдэд өгсөн санал:

№	ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн нэрс	Саналын хувь	Кумулятив аргаар өгсөн саналын тоо
1	Э.Ганбаатар	11.11%	8,421,521
2	Б.Лхамдэгд	11.11%	8,421,521
3	Э.Эрдэнэбаатар	11.11%	8,421,521
4	Б.Чулуун-Эрдэнэ	0%	0

5. Хот Девелопмент ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийн цалин, үйл ажиллагааны зардлын төсвийг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 8,421,521 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
8,421,521	100%	0	0%	0	0%

6. Хот Девелопмент ХК-ийн ТУЗ-өөс гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэртэй танилцах асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 8,421,521 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
8,421,521	100%	0	0%	0	0%

7. Хот Девелопмент ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өсгөх, хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргахыг батлах тухай асуудалд хувьцаа эзэмшигч Э.Баярбат нь Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1-т заасан сонирхлын зөрчилтэй этгээд байх тул дээрх асуудлаар санал өгөх эрхгүй болно.

Энэхүү асуудлаар санал өгөх эрхтэй хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн 100%

буюу 5,607,896 ширхэг хувьцаатай 2 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
5,607,896	100%	0	0%	0	0%

8. Хот Девелопмент ХК-ийн үйл ажиллагааны чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 8,421,521 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
8,421,521	100%	0	0%	0	0%

9. Хот Девелопмент ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 8,421,521 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэхээр хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
8,421,521	100%	0	0%	0	0%

10. Хот Девелопмент ХК нэмж хувьцаа гаргахтай холбогдуулан мөн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан хуралд оролцсон ч эсрэг саналтай байсан эсхүл хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигч нар хувьцаагаа эргүүлэн худалдан авах шаардах эрхийг хэрэгжүүлэх эсэх асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу

8,421,521 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар шаардах эрхийг хэрэгжүүлэхээр хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
8,421,521	100%	0	0%	0	0%

11. Хот Девелопмент ХК-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай асуудалд хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100% буюу 8,421,521 ширхэг хувьцаа эзэмшиж буй 3 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар хүчинтэй санал өгсөн.

Хүчинтэй санал өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 100% зөвшөөрсөн, 0% татгалзсан, 0% түдгэлзсэн байна.

Зөвшөөрсөн		Татгалзсан		Түдгэлзсэн	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
8,421,521	100%	0	0%	0	0%

Ингэснээр хурал 12:50 минутанд өндөрлөв.

Хурлын тэмдэглэлийг баталгаажуулсан Хурлын дарга Ч.Солонго



Хурлын тэмдэглэл хөтөлсөн Б.Номин

(Signature of B. Nomin)